



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2023 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2023 ОНЫ 6 ДУГААР САРЫН 08-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААН

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

*Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.*

**ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ
ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**

2023 оны 6 дугаар сарын 08-ны өдөр, Пүрэв гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
Хуралдааны товч тэмдэглэл:	2
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	3

1. **“Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл**
*/Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2023 оны 02 дугаар дүгнэлтийг
Улсын Их Хурал хүлээн авсантай холбогдуулан Монгол Улсын шүүхийн
тухай хууль, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль,
Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Иргэний хэрэг шүүхэд
хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн
төсөл боловсруулах үүрэг бүхий/*

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы
Хууль зүйн байнгын хорооны 6 дугаар сарын 08-ны өдөр
/Пүрэв гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Байнгын хорооны дарга Б.Энхбаяр ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 19 гишүүнээс 10 гишүүн хүрэлцэн ирж, 52.6 хувийн ирцтэйгээр хуралдаан 13 цаг 24 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: Ш.Адъяаа, Х.Нямбаатар, Б.Пүрэвдорж;

Чөлөөтэй: Н.Алтанхуяг;

Эмнэлгийн чөлөөтэй: Ц.Мөнхцэцэг, Ц.Сэргэлэн;

Тасалсан: Д.Ганбат, Б.Дэлгэрсайхан, Б.Энх-Амгалан.

Нэг. “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл /Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2023 оны 02 дугаар дүгнэлтийг Улсын Их Хурал хүлээн авсантай холбогдуулан Монгол Улсын шүүхийн тухай хууль, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулах үүрэг бүхий/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Ч.Батбямба, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, Хууль зүйн байнгын хороо хариуцсан референт П.Хулан нар байлцав.

Тогтоолын төслийн талаар Байнгын хорооны дарга Б.Энхбаяр танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Б.Энхбаяр: “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7

Татгалзсан: 3

Бүгд: 10

70.0 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 13 цаг 27 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 3 минут үргэлжилж, 19 гишүүнээс 10 гишүүн хүрэлцэн ирж, 52.6 хувийн ирцтэйгээр 13 цаг 27 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ДАРГА

Б.ЭНХБАЯР

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ
ШИНЖЭЭЧ

Ц.АЛТАН-ОД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ
2023 оны 6 дугаар сарын 08-ны өдөр,
Пүрэв гараг
Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар”
танхим
13 цаг 24 минут

**БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

Б.Энх-Амгалан: Хууль зүйн байнгын хорооны 2023 оны 6 дугаар сарын 08-ны өдрийн хуралдаанд Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирсэн тул хуралдааныг нээснийг мэдэгдье.

Ирцийг танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр, Э.Бат-Амгалан, С.Бямбацогт, Л.Мөнхбаатар, Ц.Мөнх-Оргил, Ш.Раднаасэд, Ц.Сандаг-Очир, Ж.Сүхбаатар, Н.Учрал, Д.Цогтбаатар нар хүрэлцэн ирсэн байна.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

“Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл.

Хэлэлцэх асуудал дээр саналтай гишүүн байна уу? Алга байна.

Хэлэлцэх асуудалдаа орё.

“Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл.

Үндсэн хуулийн цэцийн 2023 оны 02 дугаар дүгнэлтийг Улсын Их Хурал хүлээн зөвшөөрсөнтэй холбогдуулан

Монгол Улсын шүүхийн тухай хууль, Захиргааны хэргийг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулж хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах тухай тогтоолын төслийг Та бүхэнд тараасан байгаа.

Ажлын хэсгийн ахлагчаар Б.Энхбаяр, гишүүдэд Д.Ганбат, Ш.Раднаасэд, Ж.Сүхбаатар, Д.Цогтбаатар нарын бүрэлдэхүүнтэй байгуулах тогтоолын төслийг Та бүхэнд тараасан.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан асуулттай гишүүд байна уу? Алга байна.

Тогтоолын төсөлтэй холбоотойгоор гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан үг хэлэх гишүүд нэрсээ өгнө үү? Алга байна.

Тогтоолын төсөлтэй холбогдуулж гишүүд үг хэлж дууслаа.

“Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт 70 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан хаасныг мэдэгдье.

Хуралдаан 3 минут үргэлжилж, 13 цаг 27 минутад өндөрлөв.

**БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ**

Ц.АЛТАН-ОД